

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2019 ОНЫ 06 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ

2019 оны 07 дугаар сарын 04

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	”БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1.	<ul style="list-style-type: none"> - Мон-Энержи Консалт ХХК нь инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаан хангамжаас бусад бүх зураглал, тооцоолол боловсруулагдаж, хангагч байгууллагатай зөвшилцөж магадлалд оруулахаар бэлтгэж байна. - БХБЯ нь ХХААХҮЯ-аас өмнөх ТЭЗҮ-ийг авч цахилгаан хангамжтай холбоотой материалыг ЭХЯ-д хүргүүлж, ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлж, цахилгаан хангамжийн техникийн нөхцөл авах ажлыг эрчимжүүлэхээр ажилллаж байна. - Зөвлөлдөх уулзалтыг БХТ дээр 2019.06.14, 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. - Мон-Энержи Консалт ХХК нь Ерөнхий төлөвлөгөөг батлуулахаар Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газарт өгсөн. 	100%
2	”БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2	Буриад ард улсын Аж үйлдвэрийн паркттай танилцах аялал зохион байгуулах, туршлага судлах ажил түр хойшлогдсон.	0%
3	Багануур дүүргийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/147 дугаар захирамж	Байгууллагын үйл ажиллагааг шалган зааварласан ажлын хэсгийн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
4	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны А/518 дугаар захирамж	Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан Байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх сургалтад 2019.06.18-нд хамрагдсан. Улсын үзлэгт бэлтгэх Бэлтгэл ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж баталсан. Бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж 7 хоног бүр удирдлагад танилцуулж байна.	100%

5	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 10.1.	2019.06.21-ний өдөр БҮТП-д Биотехнологийг хөгжүүлэх нь уриан дор "Ховор эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах нь" сэдэвт сургалт зөвлөгөөнийг дүүргийн үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан амжилттай зохион байгуулж, Хөх нуурын био станц, Хэрлэн баян улааны ховор эмийн ургамлын плантацитай танилцаж туршлага судлав. Тус арга хэмжээнд ХААИС, ШАУИС, УХЭШХ болон ШУҮ-ийн Монхимо ХХК-иудын төлөөллүүд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын 8 илтгэл тавьж оролцлоо.	100%
6	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.2.	Паркийн санаачилгаар "Нийслэлийн паркуудын тулгамдсан асуудал ба инновацийг хөгжүүлэх арга зам" сэдэвт уулзалт зөвлөгөөнийг НШУҮИГ-т зохион байгуулахад оролцож, өөрийн паркийн тулгамдаж буй асуудал болон БҮТП-д инновацийг хөгжүүлэх нь гэсэн 2 сэдвээр илтгэл тавьж, санал зөвлөмжүүдийг сонслоо.	100%
7	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.	МУИС-тай хамтын ажиллагааны дунд хугацааны гэрээ байгуулах ажил түр хойшилсон.	0%
8	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 15.3.	Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эко хот төслийн танилцуулга, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх танилцуулгыг Багануур тохижилт ОНӨААТҮГ-ын удирдлагын зөвлөлд танилцуулж, хамтран ажиллах санал солилцож, хамтын ажиллагааны төлөвлөгөөний төсөл болон бордооны тараах материалыг боловсруулж Багануур тохижилт ОНӨААТҮГ-ийн бордоо хийх ажилтан - айл өрхөд бордоо хийх заавар, зөвлөмжийг хүргүүлсэн.	100%
9	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.3.	Дүүргийн ЖДҮДТ-тэй Хүүхдийн модон тоглоомын загвар гаргах арга хэмжээг зохион байгуулах талаар уулзалт хийж, дүүргийн хэмжээнд мод, модон эдлэлийн бүтээгдэхүүн хийдэг бизнес эрхлэгчдийг оролцуулан уулзалт зохион байгуулахаар тохиролцов.	100%
10	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.	ШУТИС-ын эрдэмтэд судлаач багш нарын бүтээлд судалгаа хийх ажлыг зохион байгуулаагүй.	0%

11	Бодлогын зорилтын баримт бичгүүдийн хүрээнд	<p>Нийслэлийн ЗДТГ-ын ХШ,ҮХ-т дараах бодлогын баримт бичгүүдийн эхний хагас жилийн биелэлтийг хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэл - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр - 2018 оны үйл ажиллагаанд ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөн - Байгууллагын 2019 оны төлөвлөгөөний - Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн, мэдээ, хэрэгжилтийн мэдээнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайланг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, №06 хуралдааны тэмдэглэлийн хамт - Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийн мэдээ <p>Нийслэлийн “Иргэдийн оролцоотой – Хөгжлийн жил” зорилтот жилийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг гаргаж НЗДТГ-ын ТЗУХ хүргүүлсэн.</p> <p>Байгууллагын 2019 оны эхний хагас жилд гадаад харилцааны чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг гаргаж НЗДТГ-ын ГХХ-т хүргүүлсэн.</p> <p>Байгууллагын даргын иргэдтэй хийсэн уулзалт болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тайлан гаргаж НЗДТГ-ын НҮНТ-д хүргүүлэв.</p>	100%
12		<p>Дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-т дараах бодлогын баримт бичгүүдийн хагас жилийн биелэлтийг хүргүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Багануур дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл - Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Иргэдийн амьдрах орчныг сайжруулах жилийн төлөвлөгөө 	100%
Нэмэлт ажлууд			
13	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг боловсруулж НШУҮИГ, БХБЯ, УУХҮЯ-дад тус тус хүргүүлсэн.		100%
14	Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулах 9 төсөл арга хэмжээний саналыг боловсруулж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Нийслэлийн ЗДТГ-ын ХБ,ТХ болон дүүргийн ТЗУХ-т тус тус хүргүүлэв.		100%

15	2019.06.12-нд “Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналтын карт нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтад Захиргааны албаны ахлах мэргэжилтэн, Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн нар хамрагдсан.	100%
16	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/143 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019.06.09-нд дүүргийн ЗАА-аас зохион байгуулсан “Өгөөмөр өдөр” өдөрлөгт оролцож, тайланг хүргүүлэв.	100%
17	БХБЯ-аас КОЙКА-гийн шугамаар Сангийн яаманд 3н төсөл оруулахаар болсны нэгээр БҮТП-ийн дэд бүтцийн төслийг оруулах санал тавьсан тул Төслийн ерөнхий танилцуулгыг англи, монгол хэл дээр бэлтгэж хүргүүлсэн.	100%
18	Паркад Зохион бүтээх инженер, Төслийн эдийн засагч мэргэжлээр ажиллах төгсөх курсийн оюутнуудаас ажилд авах саналыг ШУТИС, МУИС-иудын захиргаанд тавив.	50%
19	Мэдээлэл, технологийн газрын мэргэжилтэн цаг бүртгэлийн машиныг программ хөгжүүлэгч инженерт шилжүүлсэн. Одоогийн байдлаар цаг бүртгэлийг гараар бүртгэн ажиллаж байна.	50%
20	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад 2019.06.18-ны өдөр хамрагдсан.	100%
21	Азийн хөгжлийн банкнаас МУ-д Шинжлэх ухааны парк байгуулах төслийг хэрэгжүүлэх байршил тогтоох зорилготой ажлын хэсгийн гишүүдтэй уулзаж Паркийн өнөөгийн байдал, дэд бүтэц, газар ашиглалтын тухай мэдээлэл өгч ажилласан. Төсөл хэрэгжүүлэгчийн талаас ШУП байгуулахад тохиромжтой байршлын хувьд Багануур дүүргийг онцлон дэвшүүлэх тухай саналаа тус уулзалтаар илэрхийлсэн.	100%
22	Манай хороо – Миний гудамж аяны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу арга хэмжээг зохион байгуулан ажиллаж 6 дугаар сарын тайланг дүүргийн ЗАА-нд хүргүүлсэн.	100%
23	2019.06.27-нд Авлигийн тухай дүүргээс зохион байгуулсан сургалтад хамт олноороо хамрагдсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг гаргаж удирдлагад танилцуулсан.	100%
24	Байгууллагын албан хаагчдын хагас жилийн тайланг дүгнэх, 3 дугаар улирлын төлөвлөгөөг батлах ажлыг зохион байгуулж ажилласан.	100%
25	Байгууллагын эд хөрөнгийн 2 дугаар улирлын тооллогыг явуулж тайланг удирдлагад танилцуулсан. Тооллогоор зөрчил илрээгүй.	100%
26	Паркийн тулгамдсан асуудлын талаар дүүргийн Засаг даргатай уулзалт зохион байгуулж Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлэхээр санал солилцсон.	100%
27	Инновацийн сангаас зохион байгуулсан төсөл сонгон шалгаруулалтын 2 дугаар шатны шалгаруулалтад тэнцсэн 2 үйлдвэрийн төслийг эцсийн шатны шалгаруулалтад бэлтгэж, УБ танилцуулга хийсэн.	100%
28	Нийслэлийн Өмч ашиглалт удирдлагын газарт Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнүүлж ажилласан.	100%

29	Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтэст 2018 оны бодлогын баримт бичиг болон санхүүгийн тайланг хүргэж өгсөн бөгөөд шалгуулж байна.	100%
30	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 сарын 21-ний өдрийн А/619 дугаар захирамжаар Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төслийн 35 сая төгрөг болон Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх 30 сая төгрөгийн санхүүжилт тус тус шийдвэрлэгдсэн тул бэлтгэл ажлыг хангаж эхэлсэн.	100%
31	2019.06.28 нд “Улаанбаатар эдийн засаг 2019” форумд оролцсон.	100%

ХЯНАСАН:



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

Ч.ЭЛБЭГСАЙХАН

“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ-ын дарга

Б.Мичид-Эрдэнэ
Ахлах мэргэжилтэн